



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Булган сумын Сум дундын ойн ангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/128/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn
	Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn
	Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.16 № 29

танай _____ ны № _____ т

БУЛГАН СУМЫН
СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ДАРГА Б.АЛТАНСҮХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Сум дундын ойн ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Сум дундын ойн ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Ойн газартай байгуулсан 140/2023-1 гэрээний 3.2, хавсралтын 1-ийн 3.4-т заасныг зөрчин 2.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд ойн Бургасны плантаци байгуулах, ойн үрийн тайлбайн арчилгааны ажлыг Ойн газартай гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг.

• 006020065

Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Булган сумын Сум дундын ойн анги 1 хөтөлбөр 1 зориулалт арга хэмжээний хүрээнд 84.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 80.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	62,182,987.8	41,787,152.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	77,605,832.2	99,876,668.5
	Нийт хөрөнгийн дүн	139,788,820.0	141,663,821.3
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	139,788,820.0	141,663,821.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	139,788,820.0	141,663,821.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	41,787,152.8	62,182,987.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	99,876,668.5	77,605,832.2
	Үйл ажиллагааны үр дүн	141,663,821.3	139,788,820.0
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	141,663,821.3	139,788,820.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	53,106,113.2	141,663,821.3
	Тайлант оны үр дүн	88,557,708.1	(1,875,001.2)
	Эцсийн үлдэгдэл	141,663,821.3	139,788,820.0
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	137,060,490.0	139,134,866.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	134,080,690.0	139,134,866.0
	Үйл ажиллагааны ЦМГ	2,979,800.0	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(2,979,800.0)	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	81,762,844.5
	Урсгал зардал	-	81,762,844.5
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	107,184,866.0
	Улсын төсвөөс санхүүжих	-	62,826,300.0
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	44,358,566.0

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,437.1 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 16,437.1 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Талбай тусгаарлалтын гэрээний дагуу 14,673.9 мянган төгрөгийн авлагыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй,

мөн бараа материалын 1,763.2 мянган төгрөгийн орлогын гүйлгээг бүртгэхдээ НББ-ын тухай хуулийн 6.1, НБББББ-ын 5.3.2-т заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитаар нийт 30,710.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 2,260.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 28,450.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

3.2 Албан шаардлага

Ойн газартай байгуулсан 140/2023-1 гэрээний 3.2, хавсралтын 1-ийн 3.4-т заасныг зөрчин хөрөнгө бэлтгэн зориулалт бус зарцуулсан нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох

3.3 Зөвлөмж

Ойн газартай байгуулсан 140/2023-1 гэрээний 3.2, хавсралтын 1-ийн “санхүүжилтийн журам”-ын 3.5-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мод шилжүүлэн суулгах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, хяналт тавьж ажиллах

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Булган сум СДОА	2	16.4	0.0	-	2	16.4	2	16.4	0.0	0.0	0.0	0.0
Дүн	2	16.4	0.0	-	2	16.4	2	16.4	0.0	0.0	0.0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Булган сум СДОА	2	30.7	0	-	1	2.3	1	28.5	0	-	0	-
Дүн	2	30.7	0	-	1	2.3	1	28.5	0	-	0	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Булган сум СДОА	1	56.0					1	56.0
Дүн	1	56.0	0	-	0	-	1	56.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	-	0	-	0	-	0	-
Нийт дүн	1	56.0	0	-	0	-	1	56.0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		